



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 11 сарын 12 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль¹, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль², Эрүүл мэндийн даатгалын тухай хууль³, Нийгмийн даатгалын ерөнхий хууль⁴, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй орлогыг төвлөрүүлнэ:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,746,739.5
	1.1 Ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэл	1,190,982.8
	1.2 Төрөөс эрүүл мэндийн даатгалыг нь хариуцах иргэдийн улсын төсвөөс төлөх шимтгэл	431,181.3

¹Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

²Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

³Эрүүл мэндийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

⁴Нийгмийн даатгалын ерөнхий хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 31 дугаарт нийтлэгдсэн.

	1.3	Төр хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	1,067,035.4
	1.4	Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	57,540.1
Нийт орлого			2,746,739.5

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй эргэн төлөх төлбөрийг төлнө:

Д/д	Төсвийн ерөнхийлөн захирагч	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	75,500.0

5 дугаар зүйл. 2026 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч доор дурдсан хэмжээтэй төсвийг зарцуулна:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	2,458,751.5
	1.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний санхүүжилт	2,275,447.3
	1.2 Эмийн үнийн хөнгөлөлт	169,774.4
	1.3 Үйл ажиллагааны урсгал зардал	13,529.7
Нийт зарлага		2,458,751.5

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ